



# “ГУРИЛ ТЭЖЭЭЛ БУЛГАН” ХК

Монгол Улс, Булган аймаг, Булган сум, Зүүн түрүү, 4-р баг, Утас: 22917, Факс:70071777

20~~21~~ оны 03 сарын ~~21~~ өдөр

№ ~~7/21-01~~

Булган

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал  
хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.2, 61.1.5, 76.1.2, 80.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Гурил тэжээл булган” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутаас ”Нэхээсгүй эдлэл“ ХК-ийн хурлын байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
  - Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
  - ТУЗ-ийн гишүүдийг сонгох
  - Компанийн ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргын цалин, ТУЗ-ийн зардлын төсвийг батлах
  - ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 сарын 15-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг 2021 оны 03 сарын 26-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2020 оны 04 сарын 10-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Тухайн хавсралтад заасан баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг бэлэн болгох эцсийн хугацааг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөр тогтсугай. Хавсралт №3-д заасан баримт бичгийг ажлын өдрүүдэд 09<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд ХУД, 15-р хороо,

- 50-р байрны, 15 давхарт байрлах төв оффис болон компанийн өөрийн байран дээрээс ирж танилцаж болохыг дурдсугай.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.
  8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2020 оны 04 сарын 30-ны 08 цаг 50 минут хүртэл байхаар тогтоосугай.
  9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын дарга, хурал зохион байгуулах комиссийн даргаар Б.Мөнхбаяр, хурал зохион байгуулах комиссын гишүүнээр Б.Насанжаргал, тооллогын комиссын даргаар Ө.Оюун-Эрдэнэ, тооллогын комиссын гишүүнээр П.Хишигжаргал, Н.Цэцэгдэмбэрэл нарыг тус тус томилсугай.
  10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах, тухайн тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Насанжаргал, Ө.Оюун-Эрдэнэ нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Handwritten signature of B. Ganbat in black ink, written over a red circular official stamp.

/Б.ГАНБАТ/